



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/620

Мөрөн сум

Малын гоц халдварт өвчнөөс
урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны 2022 оны “Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр тогтоол, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны “Төлөвлөгөө батлах тухай” тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын “Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/399 дугаар тушаалын хүрээнд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд 16 сумын үхэр, сарлаг, гахайг хамруулан 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 22 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.


2. Дархлаажуулалтын арга хэмжээний ажлын хэсгийг шуурхай зохион байгуулан ажиллах хүн хүч, шатахуун, автомашинаар ханган явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Дархлаажуулалтад шаардагдах вакциныг сумдад хуваарилан, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж, тайлан мэдээг холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Л.Ариунаа)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Г.Гандэлгэр)-т даалгасугай.

ДАРГА

Л.ТӨМӨРБААТАР



Захирамж2024

6712011856